


**БАТЛАВ  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН  
САЙД**



**О.АЛТАНГЭРЭЛ**

## **ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

### **Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага**

#### **1.1.Хууль зүйн үндэслэл**

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн.” гэж, Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх, хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх үндсэн үүргийг ёсчлон биелүүлэх” гэж, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Засгийн газар нь хүний эрх, эрх чөлөө, жөндөрийн эрх тэгш байдлыг хангах эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон шаардлагатай бусад баталгааг бүрдүүлэх, бэхжүүлэх арга хэмжээ авна.” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.6.1-д “нийгмийн бүх түвшинд шударга ёсыг бэхжүүлэх бодлогын болон хууль, эрх зүйн орчин бүрдэнэ.” гэж тусгасан.

#### **2.1.Практик шаардлага**

Улсын хэмжээнд 2024 онд 30977 зам тээврийн осол, хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 22.8 хувиар өсөж, нийт ослын 26056 буюу 84.1 хувь нийслэлд, 4921 буюу 15.9 хувь нь орон нутагт бүртгэгдэж, зам тээврийн осол хэргийн улмаас 631 хүний амь нас хохирч, 3862 хүн гэмтсэн нь өмнөх оны үеэс хүний амь нас хохирсон тохиолдол 14.5 хувиар, гэмтсэн хүн 30.0 хувиар тус тус өссөн байна.

2024 оны байдлаар улсын хэмжээнд согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил 28155, жолоодох эрхтэй үедээ согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн 22975, эрхээ хасуулсан үедээ согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн 2150, эрхгүй этгээд согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн 3030, жолоодох эрхгүй, эрхээ хасуулсан этгээд тээврийн хэрэгсэл жолоодсон 13953 зөрчил үйлдэгдсэн байна.

Зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, бууруулахаар осол, хэргийн товч мэдээлэл, шалтгаан нөхцөл, хор уршиг, эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулж, холбогдох хууль тогтоомжид нэмэлт,

өөрчлөлт оруулснаар дээрх төрлийн зөрчлийн тоо өмнөх оны үеэс тогтмол буурсан үзүүлэлттэй хэдий ч 2024 онд согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил 28155, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох гэмт хэрэг 1892 байгаа нь өмнөх оны үзүүлэлтээс 8.2 дахин өссөн байна.

Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчил, гэмт хэрэг нь нийгэм болон эдийн засгийн олон хүчин зүйлээс шалтгаалж байгаа боловч энэ төрлийн зөрчил, гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлага хангалтгүй зэргээс шалтгаалан тоон үзүүлэлт хангалттай хэмжээнд буурахгүй байна.

Иймд согтуурсан, мансуурсан этгээд тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн болон тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй этгээд тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчилд хүлээлгэх хариуцлагыг чангатгах зайлшгүй шаардлагатай байна.

Гадаадын улс орнуудын жишгээс авч үзвэл, Америкийн Нэгдсэн Улсад согтуугаар болон мансууруулах бодис хэрэглэсэн, жолооны үнэмлэхгүй тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцох үйлдлийг ноцтой зөрчилд тооцож, 10 хоногоос 6 сар хүртэл баривчлах шийтгэл оногдуулдаг. Харин жолоодох эрхийн үнэмлэхгүй тээврийн хэрэгсэл жолоодсон тохиолдолд 30 хоног хүртэл баривчлах шийтгэл оногдуулдаг байна.

Ийнхүү дээр дурдсан хууль зүйн болон практик шаардлагыг үндэслэн, олон улсын сайн туршлагыг харгалзан хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

### **Хоёр.Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа**

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлбэрээр боловсруулна.

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.18-д заасны дагуу иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн байна.

Хуулийн төсөлд тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, эсхүл тээврийн хэрэгсэл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчилд оногдуулах хариуцлагыг чангатгана. Түүнчлэн согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодох зөрчилд оногдуулах шийтгэлийг чангатгана.

### **Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар**

Хуулийн төсөл батлагдсанаар Зөрчлийн тухай хуулийн холбогдох зүйлд заасан зөрчлийн гаралт буурна гэж үзэж байна.

Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй этгээд, эсхүл согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон тохиолдолд оногдуулах шийтгэлийг чангатгаснаар зам тээврийн ослын гаралт буурах, ослын улмаас хүний амь нас, эд хөрөнгө хохирохоос урьдчилан сэргийлэх ач холбогдолтой юм.

Түүнчлэн зөрчил үйлдсэн бол хариуцлага гарцаагүй байх зарчим бодитой хэрэгжиж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд бодитой ахиц дэвшил гарна.

**Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал**

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр боловсруулах хууль тогтоомжийн төсөл байхгүй болно.

--oOo--